



## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг<sup>1</sup>)

### ЭДЛЭЭГҮЙ ҮЛДСЭН ЯЛЫГ ШИНЭЭР ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТӨГССӨН ЦАГ ХУГАЦААНААС ЭХЛЭН ТООЛНО

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** 2024/ХШТ/33

**Шүүхийн шийдвэрийн огноо:** 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр

**Шийдвэрийн төлөв:** Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн зарим заалтыг өөрчилж, шийтгэх тогтоол, магадлалын бусад заалтыг хэвээр үлдээсэн.

#### ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 96 дугаар шийтгэх тогтоолоор тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 2,800 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 2,800,000 төгрөгөөр торгох ялаар шийтгүүлсэн шүүгдэгч нь тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан үедээ дахин согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон гэх гэмт хэрэгт холбогджээ.

#### ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүхээс** шүүгдэгчийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт<sup>2</sup> зааснаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 6 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэж, Эрүүгийн хуулийн 6.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалт, 6.9 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан нийт эдлэх ялыг дараах байдлаар тооцжээ:

- Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 96 дугаар шийтгэх тогтоолоор эдлээгүй үлдсэн 1 жил, 8

<sup>1</sup> Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

[https://shuukh.mn/single\\_case/3835?daterange=2026/01/01%20-%202026/05/15%20&id=3&court\\_cat=2&bb=1](https://shuukh.mn/single_case/3835?daterange=2026/01/01%20-%202026/05/15%20&id=3&court_cat=2&bb=1)

<sup>2</sup> Эрүүгийн хууль (2015)-ийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”



сар, 1 хоногийн тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ял дээр энэ шийтгэх тогтоолоор оногдуулсан 2 жилийн хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялыг нэмж нэгтгэн нийт 3 жил 8 сар 1 хоногийн хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж;

- Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 96 дугаар шийтгэх тогтоолоор оногдуулсан ялаас эдлээгүй үлдсэн 1,396,000 төгрөгөөр торгох ялыг 93 хоног хорих ялд шилжүүлж, энэ шийтгэх тогтоолоор оногдуулсан 6 сарын хорих ял дээр нэмж нэгтгэн нийт 9 сар 3 хоногийн хугацаагаар хорих ял оногдуулжээ.

2. **Давж заалдах шатны шүүхээс** анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.
3. **Шүүгдэгчийн өмгөөлөгч хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолдоо** “... шүүгдэгчийн хувийн байдал нь 0-13 насны 4 хүүхдээ ганцаараа тэжээн тэтгэдэг, бага хоёр хүүхэд нь хоорондоо 1 насны зөрүүтэй 11 сартай, 2 настай тул эцгээрээ асран хамгаалуулж, тэжээн тэтгүүлэх боломж олгож, шүүгдэгчид оногдуулсан хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар сольж өгнө үү” гэжээ.
4. **Хяналтын шатны шүүхээс** шүүгдэгчид оногдуулсан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэн өөрчлөх үндэслэл тогтоогдсонгүй, харин шүүх **ял нэмж нэгтгэх журмыг буруу тайлбарлан хэрэглэсэн** байх тул хяналтын шатны шүүхээс энэ талаарх “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах” шаардлага бий болсон гэж үзлээ.(20)<sup>3</sup>
5. Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэмт хэрэг нь учирч болох илүү хор хохирол, эрсдэл бүхий нийгэмд аюултай үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилготой атал шүүгдэгч нь энэ төрлийн хуулиар хориглож гэмт хэрэг, зөрчилд тооцсон үйлдлийг удаа дараа гаргаж буй нөхцөл байдалд түүний хувийн байдалд хамаарах ар гэр, бага насны хүүхдүүдээ тэжээн тэтгэх үүргийг харгалзан ялыг хөнгөрүүлэх хууль зүйн үндэслэлгүй болно. (27).
6. **Шүүгдэгчийн жолоодох эрх хассан нэмэгдэл ялыг гэм буруугийн асуудлыг шүүхээр хянан шийдвэрлэсэн өдрийг хүртэл хугацаанд эдэлснээр тооцсон нь хууль зүйн үндэслэлгүй байна.**(31).
7. Шийтгэх тогтоолоор эрх хассан хугацаанд дахин согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон гэмт хэрэг үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд заасан хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах журмыг хэрэглэх хууль зүйн үндэслэл бүрдэх бөгөөд мөн зүйлийн 1 дэх хэсэгт “Ялтан оногдуулсан ялыг эдэлж дуусахаас өмнө шинээр гэмт хэрэг үйлдсэн, эсхүл шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдсон бол тухайн гэмт хэрэгт нь ял оногдуулж, өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан ялаас эдлээгүй үлдсэн ялыг нэмж нэгтгэн нийт эдлэх ялын хэмжээг тогтооно” гэж зохицуулжээ. (33).

<sup>3</sup> “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



8. Ялтны эдлээгүй үлдсэн ялыг хэзээнээс тооцохыг хуулиар тогтоосон дээрх журмын үзэл санаанд нийцүүлэн тайлбарлавал "... ял эдлэх хугацаанд шинээр гэмт хэрэг үйлдсэн ..." гэсэн агуулга нь хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах гол нөхцөл байхаар хуульчлагдсан байх тул эдлээгүй үлдсэн ялыг шинээр үйлдсэн гэмт хэргийн төгссөн цаг хугацаанаас эхлэн тоолохоор байна. (34).
9. Шүүгдэгчийн хувьд дахин согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон гэмт хэрэг үйлдсэн тэр хугацаанаас эхлэн өмнөх тогтоолоор оногдуулсан жолоодох эрх хасах нэмэгдэл ялын биелэлт зогсох бөгөөд үлдсэн ялыг шинээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулсан ял дээр нэмж нэгтгэх хууль зүйн үр дагавартай. (35).
10. Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 96 дугаар шийтгэх тогтоолоор шүүгдэгчид 2 жилийн хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ял оногдуулсан бөгөөд шүүгдэгч нь 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр дахин шинээр гэмт хэрэг үйлдсэн. Уг өдрийг хүртэл шүүгдэгч нь 95 хоног буюу 3 сар 5 хоногийн тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялыг эдэлсэн гэж үзэх бөгөөд эдлээгүй үлдсэн ял 635 хоног буюу 1 жил 9 сар байна. Эдлээгүй үлдсэн ял дээр сүүлийн шийтгэх тогтоолоор оногдуулсан 2 жилийн хугацаагаар тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах ялыг нэмж нэгтгэвэл нийт эдлэх нэмэгдэл ялын хэмжээ 3 жил 9 сар болж байх тул энэ талаар зохих өөрчлөлтийг шийтгэх тогтоол, магадлалд оруулав.

---o0o---